

Хүйс, жендэр ба жендэрийн олон янз байдал – Нэр томъёоны тайлбар

Бид хүйс, жендэрийн талаар ярих үед зөвхөн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн талаар бодох нь түгээмэл байдаг. Гэвч Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд жендэрийн олон янз байдлын талаарх ойлголтоо бид нэмэгдүүлэх нь зүйтэй. Энэ нь сэтгэлгээгээ нээлттэй байлгаж, интерсекс, трансжендэр болон ЛГБТ бэлгийн цөөнх зэрэг бусад бүлгийн хүмүүсийн талаар бодолцох хэрэгтэйг илтгэж байгаа юм.

Дараах нэр томъёоны тайлбарыг Монгол Улсын “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” (2011 он), Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “Жендэрийн аудитын чиглүүлэгчдэд зориулсан гарын авлага”-ын хоёр дахь хэвлэл (2012 он), одоогоор батлагдан гараад буй зургаан салбарын жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичиг болон Монголын ЛГБТ төвөөс гаргасан “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай хэрхэн бичих вэ?” хэвлэлийн ажилтны гарын авлага зэрэг эх сурвалжид тулгуурлав.

“Хүйс” (Sex) нь түгээмэл шинжтэй бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд төрөхөөс нь тодорхойлогдсон байдаг биологийн ялгааг илэрхийлнэ.

“Жендэр” (Gender) гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага юм.

“Жендэрийн эрх тэгш байдал” (Gender equality) гэж эрэгтэй, эмэгтэй хүмүүс улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх явдал юм.

“Жендэрийн тэгш эрх” (Gender equity) гэж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцан адилгүй хэрэгцээ, шаардлагыг хүлээн зөвшөөрч, хүн бүрт очих үр өгөөж харилцан адилгүй байлгах, хүн бүрт эрх тэгш, шударга хандах явдал юм.

“Хүйсийн баримжаа” (Gender identity) гэж хүн бүр өөрийн хүйсээ мэдэрч буй, хувь хүний дотоод мэдрэмж, баримжаа юм. Хүйсийн баримжаа нь төрөх үед оноосон хүйстэй ижил эсвэл ялгаатай байж болно.

“Жендэрийн илэрхийлэл” (Gender expression) гэж хүмүүс өөрийн хүйсийн баримжааг илэрхийлэхээр сонгосон янз бүрийн арга замууд юм. Жишээ нь: хувцас, дуу хоолой, үс, будаг шунх гэх мэт.

“Жендэрийн харилцаа” (Gender relations) бол нөөц, боломжоос хүртэх, хянах эрх мэдлийг хүйсийн хооронд хэрхэн хуваарилж буйг илэрхийлсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн харилцаа юм.

“Жендэрийн хэвшмэл үзэл” (Gender stereotype) гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлага юм.

“Жендэрийн ялгаварлан гадуурхалт” (Gender discrimination) гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

“Жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт” (Direct gender discrimination) гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг хэлнэ.

“Жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт” (Indirect gender discrimination) гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг хэлнэ.

“Бэлгийн дарамт” (Sexual harassment) гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

“Жендэрт суурилсан хүчирхийлэл” (Gender-based violence) гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

“Хүйсийн төлөөллийн доод хязгаар (квот)” (Gender quota) гэж удирдах албан тушаал дахь эрэгтэй, эмэгтэй хүний төлөөллийн доод хувь хэмжээг хэлнэ.

“Жендэрийн дүн шинжилгээ” (Gender analysis) гэж бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм. Үүнд зөвхөн хүйсээр ангилсан мэдээлэл бус, бодлогын дүн шинжилгээ, чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигладаг.

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээнд тусгах (Gender mainstreaming) бол бүх хүрээ, түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги юм.

ЛГБТ (LGBT+): Лесбиян, гей, бисексуал, трансжендэр гэсэн үгсийн товчлол. ЛГБТ хэмээх үг нь бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог. ЛГБТ хэмээх товчлолыг хэрэглэхдээ хүмүүсийг төөрөлдүүлэхгүйн тулд заавал бүрэлдэхүүн үгсийг тайлбарлах нь зүйтэй.

Сизжендэр (Cisgender): Сизжендэр бол өөрийгөө төрсөн хүйстэйгээ ижил тодорхойлж, тэр тодорхойлолтоороо амьдардаг хүмүүс юм.

Интерсекс (Intersex): Биологийн хүйс нь эм, эр аль болох нь тодорхойгүй байдлыг интерсекс гэнэ. Ген, гормон ба анатомийн олон шалтгаанаас үүдэн хүний хүйс аль болох нь тодорхойгүй байж болдог. Жишээ нь Клайнфелтеры синдром. Эцэг эх болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүс хүүхэд төрсөн даруйд түүний хүйсийг эр эмийн аль болохыг шийдэж, зөвхөн тэр хүйст нь хамаарах шинж тэмдгийг нь үлдээн, нөгөө хүйсийн шинж тэмдгийг нь хагалгаагаар авч хаядаг. Насанд хүрсэн олон интерсекс хүмүүс ийм үйл ажиллагааны эсрэг дуу хоолойгоо өргөж байгаагаас үүдэн хүүхдийг нялхад нь ийм мэс засдын ажилбар хийхээ зогсоосон. Интерсекс

гэдэг нь трансжендэр гэсэн үгтэй ижил утгатай үг биш ба энэ хоёр үгийг хооронд хольж сольж хэрэглэж үл болно.

Өөр хүйсийн хүмүүс (Non-binary): Хүйсийн баримжаа нь эрэгтэй, эмэгтэй гэх хоёр хүйсийн ойлголттой таардаггүй хүн юм. Хүйсийн баримжаанд "эмэгтэй-эрэгтэй" гэсэн хүрээнээс гадна күйир, андрогийн, шингэн, олон хүйст, хүйсгүй, өөр жендэрт зэрэг орж болно

Трансжендэр (Transgender): Өөрийн хүйсээ төрөлхийн хүйсээсээ өөрөөр тодорхойлдог, эсвэл төрөлхийн хүйсээсээ өөрөөр өөрийнхөө хүйсийг илэрхийлдэг хүмүүсийг хамарсан, тэмдэг нэрээр хэрэглэгддэг нэгдсэн нэр томъёо. Энэхүү нэр томъёонд дараах хүмүүс багтах ба эдгээр хүмүүсээр хязгаарлагдахгүй. Үүнд: транссексуал, трансвестит болон бусад хүйсийн хувьд төрөлхийн хүйсээсээ өөрөөр өөрийгөө илэрхийлдэг, тодорхойлдог хүмүүс багтана.

Трансжендэр хүмүүс ихэвчлэн эрэгтэйгээс эмэгтэй трансжендэр, эмэгтэйгээс эрэгтэй трансжендэр гэж өөрсдийгөө тодорхойлдог. Трансжендэр хүмүүс хүйсээ дааврын эсвэл мэс заслын аргаар шилжүүлэхийг сонгож ч болдог, сонгохгүй ч байж болдог.